

## САЙНЦАГААН СУМЫН 5-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ТАНИЛЦУУЛГА



Сайнцагаан сумын 5-р цэцэрлэг нь 1977 онд Дундговь аймгийн АДХГЗ-ны шийдвэрээр Зөвлөлтийн мэргэжилтнүүдийн хүүхдийн цэцэрлэгийн байр материаллаг баазыг түшиглэн барилгын 6-р трестийн ажилчдын хүүхдийг хамруулахаар 25 хүүхэд 3 ажилтантай анх байгуулагдсан. 1978 онд 50 хүүхэд, 1980 онд 75 хүүхдийн цэцэрлэг болж өргөжсөөр 1992 онд одоогийн энэ байранд орж 140 хүүхдийн хүчин чадалтай зориулалтын барилгад шилжин орж ажилласнаар СӨН-ы хүүхдийн хамран сургалт нэмэгдэн сургуулийн өмнөх насны хүүхдэд үе үеийн багш ажилчдын хөдөлмөр үйл ажиллагаагаар боловсролын үйлчилгээг хүргэж байна.

Нийт 26 багш ажиллагсадтай үүнээс эрхлэгч -1, аргазүйч-1, хөгжмийн багш-1 багш-6, туслах багш-6, нягтлан бодогч-1, эмч-1, нярав-1, тогооч-2, үйлчлэгч-1, угаагч-1, харуул хамгаалалтын ажилтан -4

Багш нар 100% мэргэжлийн, туслах багш нар 100% туслах багшийн сургалтад хамрагдсан давуу талтай.

2023-2024 оны хичээлийн жилд 6 бүлэгт 231 хүүхэд хүлээн авч сургуулийн өмнөх боловсрол олгож байна.